

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

V АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 60 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Чулуун цуглуулга

Өнөөдөр аравдугаар сарын нэгэн миний хорвоод мэндэлсэн баярын өдөр билээ. Хамгийн түрүүнд нагац эгч маань “Эрмүүн ээ, Төрсөн өдрийн баярын мэнд хүргэе. Ээж аавдаа энэрэлтэй, эмээ өвөөдөө асралтай, эх орондоо ээлтэй сайн хүн болоорой” гэж ерөн, ном, хайрцагтай чихрийн цуглуулга бэлэглэлээ. Миний хайртай зохиолчийн шинэхэн гарсан номыг бэлэглэсэнд хөл газар хүрэхгүй байв. Энэ үед Тулга найз маань манайд ирлээ. Би ч найзтайгаа чихрийн цуглуулгаа хувааж идэхээр гаргаж ирвэл “Хөөе, Эрмүүн ээ! Надад нэг санаа төрлөө. Хоёулаа чулуун цуглуулга хийе. Тиймээс чихрийн цуглуулгаа болгоомжтой задална шүү” хэмээн нүдээ онийлгон инээлээ. Ингээд чихрийн цуглуулгаа идэж дуусаад, оронд нь өнгө өнгийн чулуу хийгээд, буцаагаад наачихлаа. Анзаарга муутай хүн бол мэдэх ч үгүй гэдэгт итгэлтэй байлаа. Тулга сургуулийн хашааны хаалганы ойролцоо хайрцагтай чулуун цуглуулгаа тавиад, холгүйхэн газраас хоёул ажиглан харж, зогсохоор болов. Тэгтэл юу болсон гэж сананаа. Эхлээд үйлчлэгч Долгор эгч хөлөөрөө өшиглөхөөд явчихлаа. Дараа нь биеийн тамирын багш тоож харсан ч үгүй хажуугаар нь гарад явчхав. Харин манай хөрш айлын ах Батсуурь өшиглөж үзсэнээ газраас авч, эргүүлж тойруулж хараад, шууд л өвөртөө хийчхэв.

Тулга бид хоёр чулуун цуглуулга эзэнтэй болсонд элгээ хөштөл инээж, Батсуурь ахынд очихоор боллоо. Гэрт ортол бид хоёрын цуглуулж хийсэн хэдэн хөх чулуу хоймор нь шидээстэй. Нараа эгч үйлчихсан. Батсуурь ах хэрэг хийсэн хүүхэд аятай таг дуугүй дүмбийгээд сууж байна. Тэдний байдлыг харвал Батсуурь ах маань олж өвөртөлсөн цуглуулгаа Нараа эгчид өгсөн нь илт байв. Нараа эгчийгээ үйлуулсандаа би харамслаа. Тун тоогүй юм хийлээ дээ. Дэмий л Дөлгөөнөөс тооны номыг нь авах гэсэн юм гэвэл хөөрхий муу Нараа эгч нулимсаа гарынхаа араар арчин, хүүгийнхээ цүнхнээс тооны ном авч надад өглөө. Сэтгэл өвдөх шиг. Ахиж би хэзээ ч хүн хуурахгүй ээ. Зүггүйтэж хийсэн тэр чулуун цуглуулга ямар муухай хор уршигтай байсныг бодохоор одоо ч нурууны хөлс гардаг юм.

- “Гэрт ортол цуглуулж хийсэн хөх чулуу хойморт хэвтэх” болсны учрыг эхийн эхлэл хэсгээс олж бичээрэй. **/2 оноо/**

- A. Эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? **/1 оноо/**

B. Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. **/2 оноо/**

3. А. Тулгаагийн хийсэн үйл, хэлсэн үгийг ялган бичээрэй. /2 оноо/
-
.....
.....
.....
.....

Б. Тулгаагийн хийсэн үйл, хэлсэн үгэнд үндэслэн зан чанарыг тодорхойлж бичээрэй. /2 оноо/

.....
.....
.....
.....
.....

4. Хүснэгтэд Эрмүүний зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй.

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
.....
.....
.....
.....
Яагаад өөрчлөгдхөн болсон бэ?

5. Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж бичээд, яагаад өгүүлбэрийг сонгосноо өөрийн үгээр тайлбарлаарай. /3 оноо/
-
-
-
-
-
-
-

6. “Миний зурсан хамгийн гоё зураг” сэдвээр өөрт тохиолдсон явдлаа 100-120 үгэнд багтаан бичээрэй.

Бичихдээ:

- Эхлэлт хэсэгт – Үйл явдал өрнөсөн орчныг дүрслэн бичээрэй.
 - Гол хэсэг – Өөрт тохиолдсон, болсон явдлыг бичих
 - Төгсгөл хэсэгт – Өөрт тохиолдсон явдлаар дамжуулан бусдад ямар сургамжит санаа өгч болох вэ?
-
-
-
-
-
-
-
-
-

